

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ДОТООД АУДИТЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот



№	Аудитын ажлын нэр	Аудитын ажлын зорилго, хүрэх үр дүн	Хэрэгжилт
1	2	3	4
1.	Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах	<p>1.НХААГ-ын 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах</p> <p>2.2022 оны улс, нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах</p> <p>3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажилласнаар Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн биелэлт сайжирч, заасан хугацаанд зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлнэ.</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2023 оны 1 дүгээр улиралд “Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит тус тус хийгдсэн бөгөөд 2022 онд зохион байгуулсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 123 багц төсөл, арга хэмжээ, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 72 төсөл, арга хэмжээ аудитын түүвэрт хамрагдсан бөгөөд холбогдох үнэлгээний хорооны дарга, нарийн бичгүүд тайлбар тодруулгыг өгч ажилласан.</p> <p>“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 867 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/642 дугаар албан бичгээр тайлангийн төсөлд 10 санал хүргүүлсэн. Улмаар 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 914 дүгээр албан бичгээр гүйцэтгэлийн аудитын тайланг ирүүлсэн бөгөөд 6 саналыг хүлээж аваагүй. 4 зөрчил бүртгэгдсэн.</p> <p>“Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 875 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд холбогдох тайлбар, нотлох баримтыг Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтэс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 3/726 дугаар албан бичгээр 12 санал хүргүүлсэн. Улмаар 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 919 дүгээр албан бичгээр гүйцэтгэлийн аудитын тайланг ирүүлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 3/1707 дугаар албан бичгээр Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсээс хүргүүлж ажилласан.</p>
2.	Эрх шилжсэн худалдан авах ажиллагаа зохион	1.Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд тодорхой чиглэлээр аудит	273 төсөл, арга хэмжээ (давхардсан тоогоор)-ний үнэлгээний хорооны тайлан, дүгнэлт, 542 оролцогч (давхардсан тоогоор)-ийн мэдэгдлийг хянаж, үнэлгээний хорооны шийдвэрийг хууль тогтоомжид нийцсэн байдалд хяналт тавьж, холбогдох заавар зөвлөмжийг өгч, удирдлагыг мэдээллээр тогтмол хангаж ажилласан.



1	2	3	4
	байгуулж буй байдалд дотоод аудит хийх	хийн дүгнэлт, зөвлөмж гаргах; 2.Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд аудит хийснээр хуулийн хэрэгжилт сайжирна.	
3.	Хүний нөөцийн чиглэлээр тухайлсан ажилд аудит хийх	1.Хүний нөөцийн чиглэлээр аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах 2.Хүний нөөцийн чиглэлээр аудит хийснээр байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийн зорилго, зорилтыг хангахад учирч байгаа болон учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнийг илрүүлж, удирдлагыг шийдвэр гаргахад үнэн бодит мэдээллээр хангах;	Тус газрын "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийг газрын даргаар батлуулж, 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэсэн. Аудит хийхдээ удирдамж болон тус газрын даргын 2021 оны "Дотоод аудитын дүрэм батлах тухай" А/98 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан дүрмийн дагуу дотоод аудит хийлээ. Тус газар нь Төрийн албаны тухай хуулийн 55.3-д "Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ" гэсний дагуу газрын даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийг батлуулсан байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд жил бүр хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнан хэвшсэн байна. 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 9 зорилтын 22 арга, хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан байна. Төлөвлөгөөнд 9 зорилтын 22 арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайланг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр газрын даргад танилцуулан, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнд 5 зөвлөмжийг өгч, удирдлагад байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийн зорилго, зорилтыг хангахад учирч байгаа болон учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнийг илрүүлж, удирдлагыг шийдвэр гаргахад үнэн бодит мэдээллээр хангаж, ажиллалаа.

ТАНИЛЦСАН:  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ДОТООД АУДИТОР

Д.БАТЦЭЦЭГ

И.БААСАНЖАВ